ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завханмандал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/11/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай сум<br>2022 он | Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа<br>Утас: 99993365<br>Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор Б.Дагвасүрэн<br>Утас:99014227<br>Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn<br><br>Аудитор Ц.Оюунсувд<br>Утас: 99076038<br>Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ........................................................ **Error! Bookmark not defined.**

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................................ 3

3. Аудитын тайлан ........................................................ 11

3.1 Ерөнхий зүйл ........................................................ 11

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................................ 11

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................................ 11

3.4 Материаллаг байдал ........................................................ 12

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........................................................ 12

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........................................................ 12

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........................................................ 13

3.8 Аудитын гол асуудал ........................................................ 13

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........................................................ 13

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................................ 14

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................................ 14

4. Аудитын илрүүлэлт ........................................................ 14

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........................................................ 16

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.25 № 1302/380

танай ________ -ны № ________ -т

ЗАВХАНМАНДАЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ө.ДУЛАМСҮРЭН-д

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завханмандал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Завханмандал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бус, үрэлгэн зарцуулсан, 7.4 сая төгрөгийг нярвын хувийн дансаар дамжуулан зарцуулсан, 1.3 сая төгрөгийн шатахууныг үрэлгэн зарцуулсан, улс төрийн албан хаагчид 1.1 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, 2.9 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй, аймгийн Засаг даргын захирамжаар ковидын дэмжлэгт олгосон 5.0 сая төгрөгийг тахилгын үйл ажиллагаанд зарцуулж, зарцуулалтыг үнэн зөв тайлагнаагүй зэрэг зөрчлүүд нь (*Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1; 16 дугаар зүйлийн 16.5.5; 41 дүгээр зүйлийн 41.2.3; Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Татварын ерөнхий хуулийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь; Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3, 1.4, Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 3.1, 6.2 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй*) байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Audit(D)A4-тоот/2022

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **52,108,827.20** | **24,889,060.20** |
| **33** | **АВЛАГА** | 490,720.00 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 490,720.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 51,618,107.20 | 24,889,060.20 |
| **354** | **Хангамжийн материал** | 33,693,107.20 | 24,889,060.20 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,072,240.00 | 3,468,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,071,300.00 | 699,300.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 66,000.00 | - |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 9,470,207.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | 70,000.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 19,943,360.20 | 20,720,860.20 |
| 35600 | Мал амьтад | 17,925,000.00 | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 740,458,257.46 | 752,442,716.43 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 740,458,257.46 | 752,442,716.43 |
| **392** | **Биет хөрөнгө** | 730,848,257.46 | 743,432,716.43 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 523,270,109.68 | 523,270,109.68 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (53,606,725.83) | (69,408,043.83) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 82,590,000.00 | 82,590,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (52,037,121.52) | (62,787,121.36) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 103,891,780.47 | 122,071,780.47 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (68,344,782.45) | (81,259,881.85) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 54,457,925.52 | 59,924,925.52 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (38,726,173.80) | (42,723,775.67) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 514,227,382.25 | 566,896,382.25 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (334,874,136.86) | (355,141,658.78) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 9,610,000.00 | 9,010,000.00 |
| 39301 | Программ хангамж | 3,502,000.00 | 3,502,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,402,000.00) | (2,002,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,510,000.00 | 7,510,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 792,567,084.66 | 777,331,776.63 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 1,280,447.00 | - |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,280,447.00 | - |
| **413** | **Өглөг** | 1,280,447.00 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,280,447.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 791,286,637.66 | 777,331,776.63 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 791,286,637.66 | 777,331,776.63 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГ-ын сан/ | 911,194,853.89 | 911,194,853.89 |
| 51101 | Өмч: - төрийн | 911,194,853.89 | 911,194,853.89 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (257,445,076.69) | (271,399,937.72) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (162,754,837.42) | (284,840,283.69) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (94,690,239.27) | 13,440,345.97 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 137,536,860.46 | 137,536,860.46 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 792,567,084.66 | 777,331,776.63 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **үЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **318929780** | **427320137** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **9,649,700.00** | **76,456,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **9,649,700.00** | **76,456,000.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 9,649,700.00 | 76,456,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 9,649,700.00 | 76,456,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **309,280,080.00** | 350,864,137.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 309,280,080.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 305,751,337.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 3,528,743.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 45,933,437.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 7,590,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 38,343,437.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 304930700 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 304930700 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **365,717,919.89** | **413,879,791.03** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **365,717,919.89** | **413,879,791.03** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 359,706,902.12 | 383,027,368.03 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 199,448,682.00 | 199,799,473.00 |
| 210101 | Үндсэн цалин | 199,448,682.00 | 179,120,251.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 20,679,222.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 25,472,924.22 | 27,088,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,328,641.00 | 19,062,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,038,664.00 | 2,006,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,620,556.00 | 1,605,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 407,736.22 | 401,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,077,327.00 | 4,013,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,498,130.00 | 34,828,923.88 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,462,158.00 | 2,196,415.48 |
| 210302 | Түлш, халаалт | 9,035,972.00 | 32,632,508.40 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,980,431.00 | 16,515,660.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,896,400.00 | 2,613,040.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,244,994.00 | 11,708,720.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,671,037.00 | 2,193,900.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,078,700.00 | - |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 89,300.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 222,400.00 | 1,807,476.12 |
| 210604 | Урсгал засвар | 222,400.00 | 1,807,476.12 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,773,100.00 | 3,100,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,773,100.00 | 3,100,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,454,314.00 | 3,410,445.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,298,179.00 | 2,067,573.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 232,100.00 | 232,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100.00 | 469,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227,135.00 | 227,700.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 73,800.00 | 73,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 203,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 138,300.00 | 136,772.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 15,700.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 78,856,920.90 | 96,476,990.03 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,627,825.00 | 31,842,049.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 303,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 72,229,095.90 | 64,331,541.03 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,011,017.77 | 30,852,423.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,384,800.00 | 6,357,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 5,384,800.00 | 6,357,200.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 626,217.77 | 24,495,223.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 626,217.77 | 24,495,223.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(46,788,139.89)** | **13,440,345.97** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 47,902,099.38 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 47,902,099.38 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (47,902,099.38) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(94,690,239.27)** | **13,440,345.97** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл** | 911,194,853.89 | 137,536,860.46 | -162,754,837.42 | 885,976,876.93 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **911,194,853.89** | **137,536,860.46** | **-162,754,837.42** | 885,976,876.93 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -94,690,239.27 | -94,690,239.27 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **911,194,853.89** | **137,536,860.46** | **-257,445,076.69** | 791,286,637.66 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл** | **911,194,853.89** | **137,536,860.46** | **-257,445,076.69** | 791,286,637.66 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **911,194,853.89** | **137,536,860.46** | **-257,445,076.69** | 791,286,637.66 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | -27,395,207.00 | -27,395,207.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 911,194,853.89 | 137,536,860.46 | -284,840,283.69 | 763,891,430.66 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,822,389,707.78** | **275,073,720.92** | **-569,680,567.37** | 1,527,782,861.33 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **309,280,080.00** | **350,864,137.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **309,280,080.00** | **350,864,137.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 309,280,080.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 305,751,337.00 | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 3,528,743.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 45,933,437.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 7,590,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 38,343,437.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 304,930,700.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 304,930,700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **307,630,080.00** | **350,264,137.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **307,630,080.00** | **350,264,137.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **301,619,062.23** | **319,411,714.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 198,698,472.01 | 200,589,200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 176,135,772.01 | 178,629,531.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 22,562,700.00 | 21,959,669.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 25,963,644.22 | 27,088,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,937,444.22 | 19,062,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,006,500.00 | 2,006,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,605,200.00 | 1,605,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 401,300.00 | 401,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,013,200.00 | 4,013,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 28,098,130.00 | 35,323,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,462,158.00 | 2,690,891.60 |
| 210302 | Түлш, халаалт | 25,635,972.00 | 32,632,508.40 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,776,177.00 | 12,422,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,643,640.00 | 2,648,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,461,500.00 | 7,580,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,671,037.00 | 2,193,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 197,000.00 | 1,111,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 197,000.00 | 1,111,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,773,100.00 | 3,100,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,773,100.00 | 3,100,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,454,314.00 | 3,985,075.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,298,179.00 | 2,642,203.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 232,100.00 | 232,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100.00 | 469,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227,135.00 | 227,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 73,800.00 | 73,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 203,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 138,300.00 | 136,772.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 15,700.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 16,658,225.00 | 35,792,439.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,523,725.00 | 35,489,039.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 134,500.00 | 303,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,011,017.77** | **30,852,423.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,384,800.00 | 6,357,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 5,384,800.00 | 6,357,200.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 626,217.77 | 24,495,223.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 626,217.77 | 24,495,223.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,650,000.00** | **600,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,650,000.00** | **600,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,650,000.00** | **600,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,650,000.00 | 600,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,650,000.00 | 600,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(1,650,000.00)** | **(600,000.00)** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ЭЗА | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 311,304,400 | 304,809,977.00 | 6,494,423.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 311,304,400 | 304,809,977.00 | 6,494,423.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 304,947,200 | 298,452,777.00 | 6,494,423.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 200,654,800 | 200,589,200.00 | 65,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 178,092,100 | 178,629,531.00 | (537,431.00) |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 22,562,700 | 21,959,669.00 | 603,031.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 27,088,400 | 27,088,400.00 | - |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,062,200 | 19,062,200.00 | - |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,006,500 | 2,006,500.00 | - |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,605,200 | 1,605,200.00 | - |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 401,300 | 401,300.00 | - |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,013,200 | 4,013,200.00 | - |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 35,323,400 | 35,323,400.00 | - |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,835,600 | 2,690,891.60 | 144,708.40 |
| 210302 | Түлш, халаалт | 32,487,800 | 32,632,508.40 | (144,708.40) |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,295,900 | 12,422,200.00 | 873,700.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,209,300 | 2,648,000.00 | (438,700.00) |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,436,400 | 7,580,300.00 | 856,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,650,200 | 2,193,900.00 | 456,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,111,000 | 1,111,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,111,000 | 1,111,000.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,110,200 | 3,100,000.00 | 10,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,110,200 | 3,100,000.00 | 10,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,560,100 | 2,542,872.00 | 17,228.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,200,000 | 1,200,000.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 232,100 | 232,100.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 469,100 | 469,100.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227,700 | 227,700.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 73,800 | 73,800.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 203,400 | 203,400.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 138,300 | 136,772.00 | 1,528.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 15,700 | - | 15,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21,803,400 | 16,275,705.00 | 5,527,695.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,500,000 | 15,972,305.00 | 5,527,695.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 303,400 | 303,400.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 6,357,200 | 6,357,200.00 | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,357,200 | 6,357,200.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 6,357,200 | 6,357,200.00 | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 311,304,400 | 304,809,977.00 | 6,494,423.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 311,304,400 | 304,809,977.00 | 6,494,423.00 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 311,304,400 | 304,809,977.00 | 6,494,423.00 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 17 | 17.00 | - |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 | - |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 17 | 17.00 | - |
| 620001 | Удирдах ажилтан | 8 | 8.00 | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 7 | 7.00 | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2 | 2.00 | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **21,558,937** | **21,558,937** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **21,558,937** | **21,558,937** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 21,558,937 | 21,558,937 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,442,203 | 1,442,203 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,442,203 | 1,442,203 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 20,116,734 | 20,116,734 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,116,734 | 20,116,734 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 21,558,937 | 21,558,937 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 21,558,937 | 21,558,937 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 7,590,000 | 7,590,000 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,968,937 | 13,968,937 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Завханмандал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл,тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Оюунсувд гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хэрэгжүүлсэн.

Завханмандал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 03/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Завханмандал сумын Засаг даргын Тамгын газар нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.
Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завханмандал сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг нийт орлогоос 309.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 2.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

*/мян.төг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 490.7 | - | -490.7 |
| Бараа материал | 51,618.1 | 24,889.1 | -26,729.0 |
| Үндсэн хөрөнгө | 740,458.3 | 752,442.7 | 11,984.4 |
| **Нийт хөрөнгө** | **792,567.1** | **777,331.8** | **-15,235.3** |
| Өр төлбөр | 1,280.5 | | -1,280.5 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 791,286.6 | 777,331.8 | -13,954.8 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **792,567.1** | **777,331.8** | **-15235.3** |

Бараа материалын дансны үлдэгдэл 26,729.1 мянган төгрөгөөр буурсан нь хангамжийн материал 8,804.1 мянган төгрөгөөр, мал амьтад 17,925.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 11,984.5 мянган төгрөгөөр өссөн нь Засаг даргын нөөц хөрөнгөөс 600.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, сумын ОНХС-аас 18,180.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4,867.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдаж авсан, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 52,669.0 мянган төгрөгийн худаг олгосон болон элэгдлийн зардал хасагдсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 13,440.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 311,304.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 311,304.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 304,809.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 304,809.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны байгууллагаас 38,343.4 мянган төгрөгийн, ковидын хандив 7,590.0 мянган төгрөгийн, нийт 45,933.4 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлсэн байна.

Нэмэлт орлогын 21,558.9 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

## 3.8 Аудитын гол асуудал

Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт бус, үрэлгэн зарцуулсан, 7,414.0 мянган төгрөгийг нярвын хувийн дансаар дамжуулан зарцуулсан, 1,297.6 мянган төгрөгийн шатахууныг үрэлгэн зарцуулсан, улс төрийн албан хаагчид 1,137.4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, 2,9407 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй, аймгийн Засаг даргын захирамжаар ковидын дэмжлэгт олгосон 5,000.0 мянган төгрөгийг тахилгын үйл ажиллагаанд зарцуулж, зарцуулалтыг үнэн зөв тайлагнаагүй, нягтлан бодох бүртгэлээр тавих дотоод хяналт хангалтгүй байна.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 144 мэдээллээс 131 мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж, хугацаа хоцорсон мэдээлэл 14 байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 123,186.5 мянган төгрөгийн орлого, 82,059.0 мянган төгрөгийн зарлагыг мэдээлээгүй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн “шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалттай нийцэхгүй, тус хуулийн хэрэгжилт хангалтгүй байна” гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 52.7 сая төгрөгийн зөрчил илэрч, 3.8 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 42.3 сая төгрөгийн зөрчилд 3 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн байна. Зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй, төлбөрийн акт хугацаандаа төлөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шатахууны зарцуулалт, бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлд анхаарах шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 113,322.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 83,636.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,936.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 заалт бүхий зөвлөмж, батлагдсан орон тоо илүү ажилласан болон 22,611.6 мянган төгрөгийн болон өмнөх аудитын зөвлөмж хэрэгжүүлээгүй, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт хангалтгүй алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, улс төрийн албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгосон 1.137.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, шилэн данстай холбоотой 205,245.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

### 4.1 Залруулсан алдаа

Үр дүнгийн тайланд 8,942.6 мянган төгрөгийн, төсвийн гүйцэтгэлийн тайланд 24,495.2 мянган төгрөгийг, үндсэн хөрөнгийн тодруулгад 1,815.0 мянган төгрөгийн, бараа материалын тодруулгад 14,138.4 мянган төгрөгийн, өмнөх оны бараа материалын үлдэгдэл 26,655.7 мянган төгрөгийн, нийт 76,046.9 мянган төгрөгийн алдаанд залруулга хийгдсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Улс төрийн албан хаагчид 1,137.4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.1 “улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

### 4.3 Албан шаардлага

Засаг даргын нөөц хөрөнгөөс 8,900,000.00 төгрөгийг зориулалт бус, үрэлгэн зарцуулсан, ЗДТГ-ын үйл ажиллагааны зардлаас 7,414,000.00 төгрөгийг нярвын хувийн дансаар дамжуулан зарцуулсан, 1,297,666.00 төгрөгийн шатахууныг үрэлгэн зарцуулсан, аймгийн Засаг даргын захирамжаар ковид-19 цар тахлын дэмжлэгт олгосон 5,000,000.00 төгрөгийг тахилгын үйл ажиллагаанд зориулалт бус зарцуулж, зарцуулалтыг үнэн зөв тайлагнаагүй, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

- ✓ *1,345.7 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцэхгүй, ангилал, үнэлгээ ба хуваарилалт зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.*

1.2. *Өгсөн зөвлөмж:*

- ✓ *Батлагдсан төсвийг зарцуулахдаа Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг баримтлан ажиллаж, эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх;*

**2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

2.1. *Илрүүлэлт:*

- ✓ *2,940.7 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримтыг бүрдүүлээгүй нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

2.2. *Өгсөн зөвлөмж:*

- ✓ *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ"; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах;*

**3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

3.1 *Илрүүлэлт:*

- ✓ *2020 онд нийлүүлэгдсэн "Си-Ти-Эс" ХХК-ийн 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программыг одоог хүртэл ашиглаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, УСНББОУС 17-той нийцэхгүй, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.*

3.2 *Өгсөн зөвлөмж:*

- ✓ *"Си-Ти-Эс" ХХК-аас нийлүүлэгдсэн 1,650.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программыг 2022 оны 03 дугаар сарын 01-ээс ашиглаж эхлэх, 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг тус программаар гаргах*

**4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

4.1 *Илрүүлэлт:*

- ✓ *Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт 123,186.5 мянган төгрөгийн орлого, 82,059.0 мянган төгрөгийн зарлагыг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 3.2.10. "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн*

*гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэсэн заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээллийг хангахгүй байна.*

*4.2 Өгсөн зөвлөмж:*

- ✓ *Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь хэсэгт санхүүжилт болон түлш халаалт, тээвэр шатахуун, бараа үйлчилгээний бусад болон тэтгэмжийн зардал зэрэг 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй ажил гүйлгээг тухай бүр мэдээлж хэвших*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

*/сая. төг/*

<table>
<tr><th rowspan="3">д/д</th><th rowspan="3">Аудитад хамрагдсан байгууллагын нэр</th><th colspan="2" rowspan="2">Нийт алдаа, зөрчлийн</th><th colspan="8">Үүнээс</th></tr>
<tr><th colspan="2">Залруулга</th><th colspan="2">Төлбөрийн акт</th><th colspan="2">Албан шаардлага</th><th colspan="2">Зөвлөмж</th></tr>
<tr><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th></tr>
<tr><td colspan="12">Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</td></tr>
<tr><td>1</td><td>Завханмандал сумын ЗДТГ</td><td>11</td><td>113.3</td><td>6</td><td>83.6</td><td>1</td><td>1.14</td><td>1</td><td>22.6</td><td>3</td><td>5.9</td></tr>
<tr><td colspan="2">Дүн</td><td>11</td><td>113.3</td><td>6</td><td>83.6</td><td>1</td><td>1.14</td><td>1</td><td>22.6</td><td>3</td><td>5.9</td></tr>
<tr><td colspan="12">Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</td></tr>
<tr><td>2</td><td>Завханмандал сумын ЗДТГ</td><td>1</td><td>205.2</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>1</td><td>205.2</td></tr>
<tr><td colspan="2">Дүн</td><td>1</td><td>205.2</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>1</td><td>205.2</td></tr>
<tr><td colspan="2">Нийт дүн</td><td>12</td><td>318.5</td><td>6</td><td>83.6</td><td>1</td><td>1.14</td><td>1</td><td>22.6</td><td>4</td><td>211.1</td></tr>
</table>